



ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 02 сарын 24 өдөр

Дугаар А/116

Хэрлэн сум


Цасан оргил сайхан цанын клубт дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Биеийн тамир, спортын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, 8.1.7 дахь заалт, аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 06 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Цасан оргил сайхан цанын клубээс ирүүлсэн хүсэлтийн дагуу Эрдэнэт хотын "Сархиа" цанын баазад зохион байгуулагдах "Хүүхдийн спортын их наадамд" гүйлтийн цанын төрөлд оролцох тамирчдад 1,000,000 (нэг сая) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2.Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх "Үндэсний спорт болон спортын наадам, тэмцээнд иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ" арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Н.Үнэнбат)-д гүйцэтгэлийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Түмэнжаргал)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.АЮУРБУНЬ



۴۵۵۵

مستحق المصروف
١٢٠٠
لبنان - بيروت
محرم الحرام ١٤٣٥

[illegible]

فہرست مضامین: